							"Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам", "Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт" шинэчлэн батлах тухай тогтоолын төсөлд санал боловсруулж Хуулийн хэлтэст хүргүүлэв. - Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн хадгалах байгууламжийн төлөвлөлт, ашиглалт болон түүнд тавих хяналт алдагдах нөхцөл бий болсон тул "Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулах, галын аюулгүйн норм" БНБД-ийг баталж мөрдүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч ажиллах тухай саналыг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 02/102 дугаартай албан бичгээр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны төрийн нарийн бичгийн дарга С.Төмөрхүүд хүргүүлэв. - Барилгын хөгжлийн төвөөс 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 01/1230 дугаартай албан бичгээр ирүүлсэн "Том болон дунд оврын био хийн инженерийн байгууламжийн барилга байгууламжийн техникийн шаардлага" стандартын төсөлд санал боловсруулж 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 01/1230 дугаартай албан бичгээр хүргүүлэв. - СХГ-ын Газрын тос, байгалийн хийн стандартчиллын техникийн хороон ТХ-25-ны хуралдаанд	
--	--	--	--	--	--	--	---	--

							оролцож MNS 0216:2025, Дизелийн түлш Евро. Техникийн шаардлага, MNS 6861:2025, Дизелийн түлш. Техникийн шаардлага стандартын төслийг хэлэлцэж санал өгөв. -УОК-оос өгсөн үүрэг даалгаврын дагуу Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 208 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт гишүүнээр орж ажиллан Шатахуун түгээх станц, Хийн хангамжийн нормд нэмэлт өөрчлөлт оруулах төсөл боловсруулж ажлын хэсгийн хуралд хэлэлцүүлэв. - Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 01/4013 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу “Барилгын материал, бүтээгдэхүүний аюулгүй байдлын техникийн зохицуулалт”-ын төсөлтэй танилцаж саналыг хуулийн хэлтэст хүргүүлэв.	
1.1.3	Газрын хэвлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төсөлд санал өгөх	Улсын төсөв	Санал өгсөн эсэх 1-тийм 0-үгүй	0	0	1	Газрын хэвлийн тухай хуулийг зөрчсөн тохиолдолд экологийн цагдаагийн албан хаагч Зөрчлийн хэрэг үүсгэн шалгах хууль, эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн өөрчлөлтийн 3 удаагийн хэлэлцүүлэгт оролцож санал өгсөн.	100%

1.1.4	Ашигт малтмалын тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд санал өгөх	Улсын төсөв	Санал өгсөн эсэх 1-тийм 0-үгүй	0	1	1	Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Хууль зүй, дотоод хэргийн яаманд болсон Ашигт малтмалын тухай хууль зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 7.11 дүгээр зүйлийн 6 ба 7 дугаар заалтууд дээр Экологийн цагдаагийн албан хаагч зөрчлийн хэрэг үүсгэн шалгаж болох тухай хуулийн хэлэлцүүлэгт санал өгөв. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд саналаа нэгтгэн өгсөн.	100%
1.1.5	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал өгөх	Улсын төсөв	Санал өгсөн эсэх 1-тийм 0-үгүй	0	1	1	Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллаж хуулийн үзэл баримтлалын төслийг 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр хэлэлцэж санал өгөв. Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгөх саналыг боловсруулж, удирдлагад танилцуулан, ажлын хэсэгт 2025 оны 11 сарын 28-ны өдрийн дотоод албан бичгээр хүргүүлсэн.	100%
1.1.6	Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд санал өгөх	Улсын төсөв	Санал өгсөн эсэх 1-тийм	0	0	1	Газрын тосны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсэгт орж ажиллах албан хаагчийн нэрийг	100%

			0-үгүй				дотоод албан бичгээр ЭББГ-т хүргүүлэв.	
1.1.7	Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн санал боловсруулах.	Улсын төсөв	Боловсруулсан эсэх 1-тийм 0-үгүй	0	1	1	Монгол улсын засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн ХЭГ/327 тоот албан бичгийн дагуу Зөвшөөрлийн тухай хуулийн 8.20-8.23 дахь заалтуудын хүрээнд олгож буй цацрагийн үүсгүүртэй холбоотой тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой заалтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулж, ТЗУГ-ын Хуулийн хэлтэст дотоод албан бичгээр хүргүүлсэн.	100%
1.1.8	Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн санал боловсруулах.	Улсын төсөв	Боловсруулсан эсэх 1-тийм 0-үгүй	0	1	1	Монгол улсын засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн ХЭГ/327 тоот албан бичгийн дагуу Цөмийн энергийн тухай хуулийн 15.3.1-15.3.4 дэх заалтуудад болон тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлагууд, аюулгүй ажиллагааг хангахад тавигдах шаардлагуудад нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, ТЗУГ-ын Хуулийн хэлтэст дотоод албан бичгээр хүргүүлсэн. Цөмийн энергийн тухай хуулийн 15.3.1-15.3.4 дэх заалтын хүрээнд олгож буй тусгай зөвшөөрлүүдийг олгохдоо олон улсад ашиглаж буй зэрэглэсэн	100%

							хандлага ашиглах талаар ОУАЭА-ийн техникийн баримт бичиг TecDoc 1002, TecDoc1974 баримт бичгүүдийг судалж, санал боловсруулсан.	
1.1.9	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн санал боловсруулах.	Улсын төсөв	Боловсруулсан эсэх 1-тийм 0-үгүй	0	1	1	Монгол улсын засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн ХЭГ/327 тоот албан бичгийн дагуу Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдуулан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 34.2, 34.2.1, 34.2.2 дахь заалтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулж, ТЗУГ-ын Хуулийн хэлтэст дотоод албан бичгээр хүргүүлсэн	100%
1.1.10	Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн санал боловсруулах.	Улсын төсөв	Боловсруулсан эсэх 1-тийм 0-үгүй	0	1	1	Монгол улсын засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн ХЭГ/327 тоот албан бичгийн дагуу Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбогдуулан Зөрчлийн тухай хуулийн 12.11 дэх хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал боловсруулж, ТЗУГ-ын Хуулийн хэлтэст дотоод албан бичгээр хүргүүлсэн .	100%
1.1.11	Хил гаалийн байгууллагатай хамтран ажиллах журмын	Улсын төсөв	Боловсруулсан эсэх 1-тийм	0	1	1	Хил гаалийн байгууллагатай хамтран ажиллах журмын төсөл боловсруулж, Гаалийн ерөнхий	70%

[illegible]

1.2.1	Хяналт шалгалтын объектуудад 2026 оны эрсдэлийн үнэлгээг хийх	Улсын төсөв	Эрсдэлийн үнэлгээ хийсэн объектын тоо	2592	0	2592	2025 онд Геологи, уул уурхайн хяналтын чиглэлээр хяналт шалгалтад хамрагдсан болон хамрагдаагүй 782 объект /их эрсдэл-592, дунд эрсдэл-187, бага эрсдэл-23/, газрын тос, хийн хяналтаар 1186 объектод /их-483, дунд-658, бага-45/ цөмийн болон цацрагийн хяналтын чиглэлээр 115 объект/ их-82, дунд-27, бага-6/ -од тус тус эрсдэлийн үнэлгээ хийж гүйцэтгэлээ. Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2026 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний төслийг төлөвлөгөөт, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн болон төлөвлөгөөт бусаар хийх төслөөр хүргүүлээд байна.	100%
1.2.2	Хяналт шалгалтын 2026 оны төлөвлөгөөний төслийг боловсруулж, Хяналт үнэлгээний үндэсний хороонд хүргүүлэх	Улсын төсөв	Төслийг хүргүүлсэн эсэх 1-тийм 0-үгүй	0	0	1	Салбарын хяналтын 2026 онд хийгдэх хяналт шалгалтын төлөвлөгөөг 2025 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 01/3120 дугаартай албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүллээ. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасны дагуу, мөн салбарын хуулиуд болон холбогдох дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор Геологи, уул уурхай, газрын тос, хий, цөмийн	100%

							болон цацрагийн хяналтын чиглэлээр улсын хэмжээнд нийт 653 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт, 5 чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны хэмжээнд нийт 79 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр урьдчилсан байдлаар төлөвлөөд байна.	
1.2.3	Эрсдэлийн ангиллыг үндэслэн их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 464 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх	Улсын төсөв	Хяналт шалгалтын төлөвлөгөөний биелэлт /хувь/	73.0	50.0	75.0	Тайлант хугацаанд төлөвлөсөн төлөвлөгөөт хяналт шалгалтууд төсвийн хэмнэлттэй холбоотойгоор хяналт шалгалтын зардал хасагдсанаас шалтгаалан төлөвлөгөөт хяналт шалгалтыг зарласан хугацаанд хийгдэхгүй хойшлогдсон. 1.Геологи, уул уурхайн хяналтын чиглэлээр: Төлөвлөгөөт хяналт шалгалтыг Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 06-00/022, 09 дүгээр сарын 02-ны өдрийн 06-00/32, 10 дугаар сарын 02-ны өдрийн 06-00/35 дугаартай “Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу Нийслэл, Өмнөговь, Дундговь, Дорноговь аймгуудад байрлах ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд	100%

						төлөвлөгөөт хяналт шалгалтыг тухай орон нутгийн Засаг даргын Тамгын газрын Салбарын хяналт зохицуулалтын хэлтсийн Геологи, уул уурхай, газрын тос, хийн хяналтын улсын /ахлах/ байцаагч нар гүйцэтгэсэн. 2.Цөмийн болон цацрагийн хяналтын чиглэлээр: улсын хэмжээнд цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хууль тогтоомжийг хэрэгжилтэд хяналт тавих, цацрагийн аюулгүй байдлыг хангуулахаар 06-00/013, 06-00/012, 06-25/23 тоот удирдамж боловсруулж баталсан. Эдгээр удирдамжийн дагуу Нийслэл хот, Орхон аймагт цацрагтай холбогдол бүхий үйл ажиллагаа явуулж буй 62 аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт хийж, холбогдох хяналтын хуудсуудаар эрсдэлийг үнэлэхэд их эрсдэлтэй 7, дунд эрсдэлтэй 21, бага эрсдэлтэй 31 ААНБ үнэлэгдсэн. 2 ААНБ-ын үйл ажиллагаа зогссон байсан. Хяналт шалгалтаар давхардсан тоогоор 680 зөрчил, дутагдал илрүүлсэн. Зөрчил, дутагдлын арилгуулахаар нийт 402 заалттай улсын байцаагчийн 55 албан шаардлага хүргүүлэн хугацаатай үүрэг өгч, биелэлтэд нь хяналт тавьж ажилласан. 3 аж ахуйн нэгж,	
--	--	--	--	--	--	--	--

						байгууллагуудад зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж нийт 9.000.000 төгрөгийн торгууль ногдуулж, эрх бүхий албан тушаалтны 21 заалт бүхий 3 албан даалгавар хүргүүлж, хэрэгжилтийг хангуулсан. Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 23 аж ахуйн нэгж, байгууллагад хийхэд төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгасан байдал 80 хувьтай байна. 3.Газрын тосны чиглэлээр: Улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 06-00/001 дугаартай удирдамжийн дагуу Газрын тос олборлох, газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах, түгээх үйл ажиллагаа эрхэлж буй аж 90 ахуйн нэгж, байгууллага, иргэний 192 объектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг гүйцэтгэлээ. Хяналт шалгалтаар нийт 1812 зөрчил дутагдал илрүүлж, 157 зөрчлийг газар дээр нь арилгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах тухай улсын байцаагчийн 1112 заалттай 147 албан шаардлага гаргаж хүргүүлэн, ноцтой зөрчил илэрсэн шатахуун түгээх 9 станцын үйл ажиллагааг зөрчил арилгах хүртэл хугацаагаар түр зогсоож, зөрчил	
--	--	--	--	--	--	---	--

						үйлдсэн 18 аж ахуйн нэгжид 18.000.000 төгрөгийн шийтгэл оногдуулж аж ахуйн нэгж байгууллагын 556 албан тушаалтанд газрын тос, хийн хяналтын чиглэлээр илэрч буй зөрчлийг арилгах арга, холбогдох хууль, дүрэм журам, стандартыг мөрдөх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Хяналт шалгалтын биелэлт: Төлөвлөсөн 464 объектоос 365 буюу 80% хамрагдаж, эрсдэл үүсэх магадлал 24.7%, хууль тогтоомжийн хэрэгжилт 73.6% үнэлэгдсэн. Хяналт шалгалтаар 2875 зөрчил илэрснээс 878 буюу 66%-ийг газар дээр арилгуулж, 12 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа улсын /ахлах/ байцаагчийн актаар зогсоож, 1852 заалт бүхий 250 албан шаардлага хүргүүлэн биелэлтийг бүрэн хангуулсан. Мөн зөрчил бүхий 37 аж ахуйн нэгжид 64 000 000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ ногдуулснаас 60 000 000 төгрөгийн буюу 94%-ийг бүрэн барагдуулж шийдвэрлэлээ.	
--	--	--	--	--	--	---	--

1.2.4	Баяжуулах, боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад ГБХНХЯ-тай хамтран төлөвлөгөөт хяналт шалгалт хийх	Улсын төсөв	Хяналт шалгалтын төлөвлөгөөний биелэлт /хувь/	-	-	75.0	1.Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамтай хамтран гүйцэтгэх Баяжуулах үйлдвэрүүдэд хийх төлөвлөгөөт хамтарсан шалгалтын 06-00/04 дугаартай удирдамжийн дагуу Дорнод, Хэнтий, Төв, Завхан, Өмнөговь, Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын Салбарын хяналт зохицуулалтын хэлтсийн Геологи, уул уурхай, газрын тос, хийн хяналтын улсын /ахлах/ байцаагч нарын бүрэлдэхүүнтэйгээр 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2005 оны 09 дүгээр сарын 30-ний өдрийг хүртэлх хугацаанд хяналт шалгалтыг хийж, гүйцэтгэв. Хяналт шалгалтаар “Эрдэнэс-Тавантолгой” ХК, “Петрочайна дачин тамсаг” ХХК, “Говь аргатай девелопмент” ХХК, “Говь шоо” ХХК, “Монголчехметалл” ХХК, “Шувуун хар уул” ХХК-ийн баяжуулах үйлдвэрүүдэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 18 заалт бүхий 7 албан шаардлага хүргүүлж, “Нордвинд” ХХК, “Арвин хүдэр” ХХК, “Бор-Өндөр мандал” ХХК, “Лут чулуу” ХХК-уудын үйл ажиллагааг	100%
-------	--	-------------	--	---	---	------	--	------

							зөрчил арилгах хүртэл Улсын байцаагчийн актаар түр хугацаагаар зогсоож, “Нордвинд” ХХК, “Бор-Өндөр мандал” ХХК, “Лут чулуу” ХХК-уудын дотоод хяналтын нэгжгүй үйл ажиллагаа явуулж байсан зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйлийн 1.2 заалтын дагуу тус бүр 1000 нэгжийн торгуулийн шийтгэл оногдуулж ажиллалаа. 2.Дорнод, Хэнтий, Төв, Завхан, Өмнөговь, Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын Салбарын хяналт зохицуулалтын хэлтсийн Геологи, уул уурхай, газрын тос, хийн хяналтын улсын /ахлах/ байцаагч нарын бүрэлдэхүүнтэйгээр 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2005 оны 09 дүгээр сарын 30-ний өдрийг хүртэлх хугацаанд хяналт шалгалтыг хийж, гүйцэтгэв. Хяналт шалгалтаар “Эрдэнэс-Тавантолгой” ХК, “Петрочайна дачин тамсаг” ХХК, “Говь аргатай девелопмент” ХХК, “Говь шоо” ХХК, “Монголчехметалл” ХХК, “Шувуун хар уул” ХХК-ийн баяжуулах үйлдвэрүүдэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 18 заалт бүхий 7 албан шаардлага хүрргүүлж,	
--	--	--	--	--	--	--	---	--

							“Нордвинд” ХХК, “Арвин хүдэр” ХХК, “Бор-Өндөр мандал” ХХК, “Лут чулуу” ХХК-уудын үйл ажиллагааг зөрчил арилгах хүртэл Улсын байцаагчийн актаар түр хугацаагаар зогсоож, “Нордвинд” ХХК, “Бор-Өндөр мандал” ХХК, “Лут чулуу” ХХК-уудын дотоод хяналтын нэгжгүй үйл ажиллагаа явуулж байсан зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйлийн 1.2 заалтын дагуу тус бүр 1000 нэгжийн торгуулийн шийтгэл оногдуулж бүрэн барагдуулж ажиллаа.	
1.2.5	Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг шийдвэрлэх	-	Зөрчил гомдлын шийдвэрлэлт /хувь/	0.0	100	100	Тайлант хугацаанд хэлтсийн хэмжээнд зөрчлийн талаарх 60 гомдол мэдээлэл ирснийг Зөрчлийн тухай хуулийн дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, 60 аж ахуйн нэгжийн зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн. Үүнээс: - геологи, уул уурхайн хяналтын чиглэлээр 55 тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжид 550 сая төгрөгийн, - цөмийн болон цацрагийн хяналтын чиглэлээр 4 аж ахуйн нэгжид 12 сая төгрөгийн, - газрын тос хийн, хяналтын чиглэлээр 1 аж ахуйн нэгжид нэг сая төгрөг, нийт 563 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийн талаарх гомдлыг	100%

							100% шийдвэрлэж, торгуулийг бүрэн барагдуулсан.	
1.2.6	Геологи, уул уурхай, газрын тос, хий, цөмийн болон цацрагийн хяналтын чиглэлээр иргэн, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэх.	Улсын төсөв	Өргөдөл гомдлын шийдвэрлэлт /хувь/	-	100.0	100.0	Өргөдөл гомдол 8-г хүлээж авснаас 6-г хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, 2 өргөдөл гомдлыг томилолтын зардалгүй шалтгаанаар хүлээгдэж байна. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас газрын тос, хийн хяналтын чиглэлээр ирүүлсэн нийт 45 хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэн ажиллаа. Засах	100%
1.2.7	Салбарын хяналтын газрын 2026 оны хяналт шалгалтын төлөвлөгөө, объектын жагсаалтыг батлуулж, олон нийтэд мэдээлэх.	Улсын төсөв	Олон нийтэд мэдээлсэн эсэх: 1-тийм 0-үгүй	0	0	1	2026 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 01/3193 дугаартай албан бичгээр хүргүүллээ. 2026 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 01/3193 дугаартай албан бичгээр хүргүүллээ. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд Засгийн газрын 2023 оны “Хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт батлах тухай” 195 дугаар тогтоолоор баталсан	100%

							эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн Дорнод, Дорноговь аймгуудын холбогдох аж ахуйн нэгж байгууллага, сүүлийн 4 жилийн байдлаар хяналт шалгалтад хамрагдаагүй Баянхонгор, Ховд, Говь-Алтай, Завхан, Хөвсгөл, Булган, Дархан-Уул, Төв аймгуудад байрлах улсын хэмжээнд уул уурхайн салбарын ач холбогдол бүхий томоохон аж ахуйн нэгж байгууллагуудад геологи уул уурхайн хяналтын чиглэлээр ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ашиглалт, баяжуулалтын технологи, хаягдлын сангийн үйл ажиллагаа, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлт, газрын тос, хийн хяналтын чиглэлээр газрын тос, хий хадгалах даралтат сав, шугам хоолойн үйл ажиллагаа, үйлдвэрийн тоног төхөөрөмж, бүтээгдэхүүний чанар, стандарт, нөөцлөх савны багтаамж, хүчин чадал, цөмийн болон цацрагийн хяналтын чиглэлээр цацрагийн үүсгүүр ашиглан үйл ажиллагаа явуулдаг тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн цацрагийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа, дотоод хяналтын үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор төлөвлөгөөт	
--	--	--	--	--	--	--	--	--

							хяналт шалгалт хийхээр төлөвлөв. 2026 оны төлөвлөгөөт хяналт шалгалтыг геологи, уул уурхай, газрын тос, хий, цөмийн болон цацрагийн хяналтын чиглэлээр улсын хэмжээнд нийт 653 объектод хийхээр төлөвлөн Сайдын тушаалыг бэлтгэн хүргүүлсэн.	
1.2.8	Шилэн хяналтын системд геологи, уул уурхай, газрын тос, хий, цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагчдын оруулж буй хяналт шалгалтын мэдээллийг хянах, нэгтгэх	Улсын төсөв	Мэдээлэл оруулсан эсэх : 1-тийм 0-үгүй	0	1	1	Шилэн хяналтын цахим системд 2025 онд төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр зарлагдсан 464 объектын мэдээллийг геологи, уул уурхай, газрын тос, хий, цөмийн болон цацрагийн хяналтын чиглэлийн 42 улсын /ахлах/ байцаагчид бүрэн оруулж баталгаажуулсан. Мөн Улсын /ахлах/ байцаагчдын шилэн хяналтын цахим системийн ашиглалт, төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, бусад хяналт шалгалтын мэдээллийг оруулж буй байдалд хагас бүтэн жилээр нэгтгэн дүгнэж ажиллалаа. Жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд шилэн хяналтын цахим системд төлөвлөгөөт хяналт шалгалтын 464 объектоос 374 буюу 90%-г бүртгэсэн ба 358 объект хяналт хийсэн төлөвтэй, 16 объектыг эхлүүлсэн төлөвтэй байна. Мөн төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх шалгалтад хамрагдсан 108 объект,	100%

							төлөвлөгөөт бус урьдчилан сэргийлэх шалгалтад хамрагдсан 144 объектын мэдээллийг оруулж баталгаажуулсан.	
1.3.	Хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах.							
Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх								
1.3.1	Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй байгууллагын дотоод хэрэгцээний шатахуун түгээх станцын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх.	Улсын төсөв	Илэрсэн зөрчил арилгуулалт /хувь/	-	100	100	Улсын ерөнхий байцаагчийн баталсан “Байгууллагын дотоод хэрэгцээнд ашиглагдаж байгаа шатахуун түгээх станц үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай” 06-00/002 дугаартай удирдамжийг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 11/150 дугаартай албан бичгээр аймаг нийслэлийн Засаг даргад хүргүүллээ. Удирдамжийн дагуу нийслэл хотод үйл ажиллагаа явуулж байгаа 10 аж ахуйн нэгжийн дотоод хэрэгцээний 12 шатахуун түгээх станц, тэдгээрийн нийт 36 инженер техникийн ажилчдыг байлцуулан шалгахад нийт 38 зөрчил дутагдал илрүүлж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах тухай улсын байцаагчийн 38 заалттай 7 албан шаардлага гаргаж хүргүүлэн, хяналт шалгалтад хамрагдсан 10 аж ахуйн нэгж байгууллагын 36 албан тушаалтанд газрын тос, хийн	100%

							хяналтын чиглэлээр илэрч буй зөрчлийг арилгах арга, холбогдох хууль, дүрэм журам, стандартыг мөрдөх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, 49 заалт бүхий 5 зөвлөмж өгч ажиллалаа. Хяналт шалгалтад хамрагдсан объектын 4 буюу 33.3 хувь нь “Дунд” эрсдэлтэй, 8 буюу 66.6 хувь нь “Бага” эрсдэлтэй тус тус үнэлэгдэж Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн биелэлт 87.5 хувьтай байна. Хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийг 100% арилгуулж, албан шаардлагын хэрэгжилт бүрэн хангагдсан.	
1.3.2	Олон нийтийн үйлчилгээний газар, худалдаа үйлчилгээний төвд ашиглагдаж буй шингэрүүлсэн шатдаг хийн тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт хийх	Улсын төсөв	Илэрсэн зөрчил арилгуулалт /хувь/	-	100	100	Улсын ерөнхий байцаагчийн баталсан “Олон нийтийн үйлчилгээний газар, худалдааны төвд ашиглагдаж байгаа шингэрүүлсэн шатдаг хий, хийн тоног төхөөрөмж, хий борлуулах цэгийн аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай” 06-00/003 дугаартай удирдамжийг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 11/150, 11/151 дугаартай албан бичгээр Нийслэлийн хяналт шалгалтын газар болон 21 аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга нарт тус тус хүргүүлсэн.	100%

							Хяналт шалгалтад нийслэл, орон нутагт олон нийтийн үйлчилгээний газар, худалдааны төвд ашиглагдаж байгаа 150 аж ахуйн нэгж, байгууллага, 43 иргэний 181 цайны газар, ресторан, шингэрүүлсэн шатдаг хий борлуулах 12 цэг нийт 193 объектыг хамруулан шалгаж нийт 1617 зөрчил дутагдал илрүүлж, 815 зөрчлийг газар дээр нь арилгуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах тухай улсын байцаагчийн 838 заалттай 104 албан шаардлага гаргаж хүргүүлэн, ноцтой зөрчил илэрсэн 2 объектын үйл ажиллагааг зөрчил арилгах хүртэл хугацаагаар түр зогсоож, зөрчил үйлдсэн 1 аж ахуйн нэгжид 500.000 төгрөгийн шийтгэл оногдуулж барагдуулалт 100 хувьтай байна. Хяналт шалгалтад хамрагдсан 166 цайны газар, ресторан, шингэрүүлсэн шатдаг хий борлуулах 10 цэгийн 358 албан тушаалтанд газрын тос, хийн хяналтын чиглэлээр илэрч буй зөрчлийг арилгах арга, холбогдох хууль, дүрэм журам, стандартыг мөрдөх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, 236 заалт бүхий 88 зөвлөмж хүргүүлж ажиллалаа.	
--	--	--	--	--	--	--	--	--

							Хяналт шалгалтад хамрагдсан объектын 40 буюу 23.3 хувь нь “Их” эрсдэлтэй, 82 буюу 47.1 хувь нь “Дунд” эрсдэлтэй, 54 буюу 31.5 хувь нь “Бага” эрсдэлтэй тус тус үнэлэгдэж Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн биелэлт 66.49 хувьтай байна. Илэрсэн зөрчлийн 50%-г газар дээр нь арилгуулж, 50%-г арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлэн биелэлт бүрэн хангагдсан.	
1.3.3	Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Улсын төсөв	Илэрсэн зөрчил арилгуулалт /хувь/	-	100	100	Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 06-00/014 дугаартай удирдамжийг Салбарын улсын ерөнхий байцаагчаар батлуулан аймгийн Засаг даргын тамгын газруудад хүргүүлсэн. Хяналт шалгалтад Баянхонгор, Булган, Баян-өлгий, Говь-Алтай, Дорнод, Дорноговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хэнтий аймгуудад хайгуулийн тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа 52 аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалтад хийсэн. Тухайн аж ахуйн нэгжүүдээс нийт 41 зөрчил дутагдал илрүүлж	100%

							15 зөрчил дутагдал газар дээр нь арилгуулж, давхардсан тоогоор нийт 19 заалт бүхий 6 албан шаардлага хүргүүлж биелэлтийг хангуулан ажиллаа. Мөн 22.500.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч барагдуулж ажилласан байна.	
1.3.4	Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Улсын төсөв	Илэрсэн зөрчил арилгуулалт /хувь/	-	100	100	Бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай 2025 оны 01 дүгээр сарын 29-ний 06-00/011 дугаартай удирдамжийг Салбарын улсын ерөнхий байцаагчаар батлуулан аймгийн Засаг даргын тамгын газруудад хүргүүлсэн бөгөөд Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Дорноговь, Хэнтий, Төв, Ховд аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалыг бичил уурхайн аргаар олборлох үйл ажиллагаа явуулж байгаа 50 нөхөрлөл хамрагдсан. Тухайн нөхөрлөлүүдэд нийт 128 зөрчил дутагдал илрүүлж, 22 зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулж, давхардсан тоогоор нийт 37 заалт бүхий 10 албан шаардлага хүргүүлэн ажилласан байна. Мөн зөрчил дутагдлыг арилгах хүртэлх хугацаагаар нийт 11 үйл	100%

							ажиллагааг түр зогсоох акт үйлдэн тухайн нөхөрлөлүүдэд хүргүүлж, 31'500'000.00 төгрөгийн торгууль ногдуулан, 28'500'000.00 төгрөгийн барагдуулалт хийсэн байна.	
1.3.5	Геологи, хайгуулын судалгаанд цацрагийн үүсгүүр ашиглаж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагад урьдчилан сэргийлэх шалгалт хийх	Улсын төсөв	Хяналт шалгалтын гүйцэтгэл	-	Гүйцэтгэл	Гүйцэтгэл	Цөмийн болон цацрагийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн баталсан Тусгай зөвшөөрөлгүй цацрагийн үүсгүүрийг илрүүлэх урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай 06-00/009 тоот удирдамжийг Ашигт малтмал, газрын тосны газрын Цөмийн болон цацрагийн хяналтын хэлтэст 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 02/292 тоот чиглэл хүргүүлэх тухай албан бичгээр хүргүүлсэн. Удирдамжийн дагуу хяналт шалгалтад геологи хайгуулын судалгаанд цацрагийн үүсгүүрийг тээвэрлэн ашиглах, хадгалуулах хүсэлтээ ирүүлсэн 5 (Жи Пи Ти ХХК, Жи И энд Эс ХХК, Гео Инженеринг ХХК, Голден каротаж ХХК, Литопро ХХК) аж ахуйн нэгж, байгууллагыг давхардсан тоогоор 7 удаа цацраг идэвхт үүсгүүрийн тээвэрлэлтийн тэмдэг, тэмдэглэгээ, сав баглаа боодлын бүрэн бүтэн байдалд цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангуулан хяналт тавьж ажилласан.	100%

						Хяналт шалгалтад хамрагдсан геологи, хайгуулын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагууд 100 хувь буюу бүгд цацрагийн үүсгүүрийг ашиглах, хадгалах, тээвэрлэх эрхийн тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байсан. Тайлант хугацаанд Жи Пи Ти ХХК-ийн 1 ширхэг (Cs-137) цацраг идэвхт үүсгүүрийг Өмнөговь аймгийн Номгон сумын Нүүрсний хайгуулын талбайд, Жи И энд Эс ХХК-ийн 1 ширхэг (Cs-137) цацраг идэвхт үүсгүүрийг Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт Газрын ховор элементийн хайгуулын судалгаанд, Гео инженеринг ХХК-ийн 1 ширхэг (Cs-137) цацраг идэвхт үүсгүүрийг Сэлэнгэ аймгийн Түшиг сумын нутагт орших “Илч” нэртэй нүүрсний уурхайд, Голден каротаж ХХК-ийн 1 ширхэг (Cs-137) цацраг идэвхт үүсгүүрийг Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутагт орших нүүрсний хайгуулын талбайд тусгай зөвшөөрөлтэйгөөр нийт 4 аж ахуйн нэгж байгууллагын 5 ширхэг цацраг идэвхт үүсгүүрийг аймаг, орон нутагт цооногийн каротажийн судалгаанд тус тус ашиглагдаж байна.	
--	--	--	--	--	--	--	--

							Хяналт шалгалтаар дээрх 5 аж ахуйн нэгж байгууллагад давхардсан тоогоор нийт 7 удаа хяналт шалгалт хийсэн. Хяналтаар цацраг идэвхт үүсгүүрийг тээвэрлэх, ашиглах, хадгалах үеийн цацрагийн аюулгүй байдлыг хангасан эсэхийг шалгахад бүгд шаардлага хангасан байсан.	
1.3.6	Тусгай зөвшөөрөлгүй цацрагийн үүсгүүрийг илрүүлэх урьдчилан сэргийлэх шалгалт хийх	Улсын төсөв	Хяналт шалгалтын гүйцэтгэл	-	Гүйцэтгэл	-	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Цөмийн болон цацрагийн хяналтын салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн баталсан 06-00/007 дугаартай удирдамжийн хүрээнд цацрагийн үүсгүүрийг тусгай зөвшөөрөлгүй импортолсон, холбогдох тусгай зөвшөөрөлгүй иргэн, хуулийн этгээдэд ханган нийлүүлсэн, шилжүүлсэн, худалдсан болон тусгай зөвшөөрөлгүйгээр цацрагийн үүсгүүрийг ашиглаж, хадгалж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах удирдамж боловсруулж, баталсан. Тус удирдамжийн хүрээнд 7 аж ахуйн нэгж байгууллагад хяналт шалгалт хийж, тусгай зөвшөөрөлгүй ашиглаж байсан 19 цацрагийн үүсгүүрийг илрүүлэн цацрагийн	100%

							аюулгүй байдлыг хангуулж, 2 аж ахуйн нэгж, байгууллага нь 8ш цацрагийн үүсгүүрт тусгай зөвшөөрлийг олгосон. 2 аж ахуйн нэгж, байгууллагад 6 сая төгрөгийн шийтгэл ноогдуулсан..	
1.3.7	Цацрагтай ажиллагчдын мэргэжлийн шарлагын тунд урьдчилан сэргийлэх шалгалт хийх	Улсын төсөв	Хяналт шалгалтын гүйцэтгэл	-	Гүйцэтгэл	-	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Цөмийн болон цацрагийн хяналтын салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр баталсан “Урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай” 06-00/006 дугаартай удирдамжийн дагуу Улсын хэмжээнд цацрагтай холбогдолтой үйл ажиллагаа явуулж буй 545 аж ахуйн нэгж, байгууллагын 2973 цацрагтай ажиллагчдын сар бүр мэргэжлээсээ шалтгаалан авч буй 15029 удаагийн хэмжилтийн дүнд холбогдох стандартуудын дагуу зөвшөөрөгдөх норм, хязгаартай харьцуулан хяналт тавьж, мэдээллийн сан бүрдүүлэн ажилласан. ТББ-аас зохион байгуулсан нийт 7 удаа салбарын 80 байгууллагын 198 оролцогчдод Мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналтын чиглэлээр мэдээлэл өгч, гарын авлага тарааж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Цацрагтай ажиллагчдын сард авч болох зөвшөөрөгдөх дундаж	100%

							хэмжээнээс өндөр гарсан давхардсан тоогоор 8 байгууллагын 10 тохиолдол илэрснийг тухай бүр цацрагийн хяналтын лабораториос албан бичгээр хүлээн авч, шалтгаан нөхцөлийг тодруулж, илэрсэн алдаа дутагдлыг арилгуулахаар тус 2 байгууллагад нийт 12 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.	
--	--	--	--	--	--	--	---	--

1.3.8	Улсын хэмжээнд төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, гүний худгийн усанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх	Улсын төсөв	Хяналт шалгалтын гүйцэтгэл	-	Гүйцэтгэл	63	Цөмийн болон цацрагийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн баталсан Улсын хэмжээнд төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, гүний худгийн усанд урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай 06-00/008 тоот удирдамжийг Ашигт малтмал, газрын тосны газрын Цөмийн болон цацрагийн хяналтын хэлтэст 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 02/292 тоот чиглэл хүргүүлэх тухай албан бичгээр хүргүүлсэн. Нийслэлийн төвлөрсөн усан хангамжийн 9, Орхон, Дорнод аймгийн эх үүсвэрээс 64 дээж авч Стандарт хэмжил зүйн газрын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори (ХАБҮЛЛ)-ийн Цацрагийн хяналтын лаборатори (ЦХЛ)-д байгалийн болон зохиомол цацраг идэвхт изотопын хувийн идэвх тодорхойлох шинжилгээнд хамруулсан. Нийслэлийн төвлөрсөн усан хангамжийн 9 эх үүсвэр /Буянт-Ухаа, Төвийн А станц, Үйлдвэрийн-Б, Махын-В, Яармаг, Гачуурт, Дээд/-ээс II, III дугаар улиралд авсан ундны усны 25 дээж, Дорнод аймгийн төвлөрсөн усан хангамжийн 1, Орхон аймгийн төвлөрсөн усан хангамжаас авсан 2	100%
-------	--	-------------	----------------------------	---	-----------	----	--	------

							нийт усны 28 дээжид байгалийн гаралтай цацраг идэвхт Радон /222Rn/ изотопын хувийн идэвх нь 5-90 Бк/л хэмжээтэй буюу Монгол Улсын стандарт “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018-д заасан ундны усны цацрагийн аюулгүйн үзүүлэлт (100 Бк/л)-ийг хангаж байна. Нийслэлийн Төв, Үйлдвэр, Мах, Яармаг, Багахангайн төвлөрсөн ус хангамжаас авсан дээжүүдэд 2025 оны I, III улиралд хийсэн цацрагийн шинжилгээний дүнгээс үзэхэд байгалийн гаралтай цацраг идэвхт Радон /222Rn/ изотопын хувийн идэвх нь 125-214 Бк/л хэмжээтэй, нийлбэр альфа идэвх нь 0.12-0.31 Бк/л хэмжээтэй буюу Монгол Улсын стандарт “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018-д заасан ундны усны цацрагийн аюулгүйн үзүүлэлтээс өндөр гарсан байна. IV улиралд авсан нийслэлийн төвлөрсөн усан хангамжийн 6 эх үүсвэр, Дорнод	
--	--	--	--	--	--	--	---	--

							аймгийн төвлөрсөн усан хангамжийн 1 эх үүсвэр (Төвийн А станц Дүнжингарав, Дээд Налайх, Багануур, Дорнод эх үүсвэр)-ийн ундны усны 14 дээжийн шинжилгээний хариу гараагүй байна. Орхон аймгийн Баян-Өндөр сумын усан хангамжаас авсан дээжид нийлбэр альфа идэвхийн утга стандартын хэмжээнээс өндөр гарсан тул давтан дээж авч, Хүнсний аюулгүй байдлын лавлагаа лабораторийн Цацрагийн хяналтын лабораторид шинжилгээнд хамруулаад байна.	
1.3.9	Импортын болон дотоодын хүнсний бүтээгдэхүүнд урьдчилан сэргийлэх шалгалт хийх	Улсын төсөв	Хяналт шалгалтын гүйцэтгэл	-	1678	-	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Цөмийн болон цацрагийн хяналтын салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан импортын хүнсний бүтээгдэхүүнийг цацрагийн шинжилгээнд хамруулах урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай 06-00/010 дугаартай удирдамжийн	100%

							хүрээнд Хүнсний аюулгүй байдал, үндэсний лавлагаа лабораторийн Цацрагийн хяналтын лаборатори Цацрагийн хяналтын лабораторид нийт 133 импортын хүнсний бүтээгдэхүүн шинжилгээнд хамрагдсан бөгөөд нийт 266 үзүүлэлтээр цацрагийн шинжилгээ хийсэн. Латви улсаас импортлогдсон 3 нэр, төрлийн лаазалсан загасан бүтээгдэхүүнд зохиомол цацраг идэвхт изотоп болох Cs-137 илэрсэн боловч Цацрагийн аюулгүйн нормын шаардлага (Цацрагийн аюулгүйн нормын зөвшөөрөгдөх хэмжээ 10-100 Бк/кг)-ыг хангаж байна..	
1.3.10	Дулааны цахилгаан станц, нам даралтын зуухнаас гарч буй хаягдал үнсэнд урьдчилан сэргийлэх шалгалт хийх	Улсын төсөв	Хяналт шалгалтын гүйцэтгэл	-	Гүйцэтгэл	-	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Цөмийн болон цацрагийн хяналтын Улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр баталсан 06-00/005 дугаартай удирдамжийн дагуу улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК, “Эрдэнэтийн дулааны цахилгаан станц” ТӨХК, Дулааны цахилгаан станц (ДЦС) –ууд II, III, IV, Амгалан дулааны станц, Сэлбэ нийт 7 дулааны станцын зуухны үнс,	100%

							хаягдал үнсэн сангийн үнснээс 20 дээж, үнсэн сан орчмын хөрсний 3 дээж нийт 23 дээжийг авч, холбогдох стандартуудын дагуу зөвшөөрөгдөх норм, хязгаартай харьцуулан хяналт тавьж, мэдээллийн сан бүрдүүлэн ажилласан. Шинжилгээний дүнгээс үзэхэд шинжлэгдсэн хөрсний 3 дээж, хаягдал үнсний 19 дээжид цацраг идэвхт изотоп, радийн эквивалентын нийлбэр идэвх Цацрагийн аюулгүйн нормоос хэтэрсэн үзүүлэлт байхгүй болно. Лабораторийн шинжилгээний дүнг шинжилгээт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлж, холбогдох албан тушаалтанд шинжилгээний дүнг танилцуулж, цацрагийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.	
Баталгаажуулалтын хяналт								
1.3.11	Газрын тос, хий хадгалах даралтат сав, шугам хоолойд техникийн магадлал, баталгаажуулалт хийх	-	Баталгаажуулалт хийсэн эсэх: 1-тийм 0-үгүй	0	1	1	Газрын тос, хий хадгалах даралтат сав, шугам хоолойд техникийн магадлал, баталгаажуулалт хийлгэх тухай 26 аж ахуйн нэгжээс ирүүлсэн хүсэлтийн дагуу ажиллаж хий хадгалах 116 даралтат савны техникийн магадлалын акт, баримтыг үндэслэн хянан	100%

							баталгаажуулж 4 даралтат савыг ашиглалтаас хасав.	
1.3.12	Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн уурхайн талбайн хилийг тогтоож шав тэмдэг тавьсан тайланг хүлээн авч хянах	Улсын төсөв	Тайланг хянасан эсэх: 1-тийм 0-үгүй	0	1	1	Тайланг хугацаанд 92 аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 105 тусгай зөвшөөрлийн талбайн хил тогтоож байнгын цэг тэмдэгт суулгасан тайланг хянаж баталгаажуулав. Тайланг хянах явцад бичиг баримт зөрчил дутагдалтай болон нүүр засвартай 8 тайланг засварлуулан хянаж баталгаажууллаа. Мөн 2023 оноос өмнө хянаж баталгаажуулсан шав тэмдгийн тайлангийн судалгааг авахаар Ашигт малтмал, газрын тосны газарт 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 03/936 дугаартай албан бичгээр хүргүүлж мэдээллийн санд нэгтгэлээ.	100%
1.3.13	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах хяналтын хуудас олгох	Улсын төсөв	Хяналтын хуудасны тоо	250	320	+80	2025 онд тэсэлгээний ажил үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудаас тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл ашиглах хяналтын хуудас хүссэн 320 хүсэлтүүдийг хянан цахимаар болон цаасаар баталгаажуулан аж ахуйн нэгжүүдэд хүлээлгэн өгсөн.	100%
1.3.14	Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тээвэрлэх хуудас олгох	Улсын төсөв	Тээвэрлэх хуудасны тоо	1500	2050	+550	Тэсэлгээний ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжүүдээс тэсрэх бодис тэсэлгээний хэрэгсэл тээвэрлэх хуудас хүссэн хүсэлтүүдийг судлан	100%

							2051 тээвэрлэх хуудсыг цахимаар болон цаасар баталгаажуулан олгож, тэсэлгээний аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм болон ажил үйлчилгээнд тавигдах дотоод хяналтыг сайжруулан ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.	
2.	ЗОРИЛТ 2. ЦАЦРАГИЙН ҮҮСГҮҮРИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ХЯНАЛТ ТАВИХ, ЦӨМИЙН МАТЕРИАЛ, ЦАЦРАГИЙН ҮҮСГҮҮРИЙН УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, ЦАХИМ СИСТЕМИЙН ХӨГЖҮҮЛЭЛТ ХИЙХ							
2.1	Цацрагийн үүсгүүртэй холбоотой үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагад цацрагийн аюулгүйн үнэлгээ хийж холбогдох эрхийн тусгай зөвшөөрөл олгох;							
2.1.1	Цацрагийн үүсгүүртэй холбоотой үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагад цацрагийн аюулгүйн үнэлгээ хийж холбогдох тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулах	Улсын төсөв	Хүсэлтийн шийдвэрлэлт /хувь/	-	100.0	100.0	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/90 дугаар тушаалаар Цөмийн энергийн тухай хуулийн 15.3-дахь хэсэгт заасан цацрагийн үүсгүүрийн тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эрхийг Төрийн нарийн бичгийн даргад шилжүүлэх тушаалын төсөл боловсруулж, баталгаажуулсан. portal.igov.mn Цахим систем дээр цацрагийн үүсгүүртэй холбоотой үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт илгээсэн 156 ААНБ-ын 237 хүсэлтийг www.igov.mn цахим системээр хүлээн авч, 148 хүсэлтэд үнэлгээ хийж, Төрийн нарийн бичгийн	100%

							даргын 2025 оны 5 удаагийн тушаалаар тусгай зөвшөөрөл олгогдсон байна. 42 ААНБ-ын 48 хүсэлт шийдвэрлэх шатандаа байна. Монгол Улс НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1540 тогтоолын хэрэгжилтийг хангах “Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгагдсан экспортын хяналтын эрх зүйн орчныг бий болгох ажлын хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 4-р сарын 28-ны өдрийн №77 дугаартай захирамжаар “Экспортын хяналтын тухай хууль” боловсруулах ажлын хэсгийн гишүүдтэй хийсэн уулзалтад оролцож цацрагийн үүсгүүр, тэсэрч дэлбэрэх бодистой холбогдох үйл ажиллагаанд олгож буй тусгай зөвшөөрөл, хяналтын тогтолцооны талаар мэдээлэл өгсөн.	
2.1.2	Олгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлэх	Улсын төсөв	Олон нийтэд мэдээлсэн: 1-тийм 0-үгүй	0	1	1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны https://mmhi.gov.mn цахим хуудасны Ил тод цэсэд цацрагийн үүсгүүрийн эрхлэх үйл ажиллагаанд олгосон тусгай зөвшөөрлүүдийг байрлуулан ажиллалаа. Portal.igov.mn цахим систем дээр цацрагийн үүсгүүртэй холбоотой үйл ажиллагаа эрхлэх хүсэлт	100%

							илгээсэн 332 аж ахуйн нэгж байгууллагын 618 хүсэлтийг www.igov.mn цахим системээр хүлээн авч 464 хүсэлтэд үнэлгээ хийж Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 9 удаагийн тушаалаар олгогдсон. 57 аж ахуйн нэгж, байгууллагын 67 хүсэлт шийдвэрлэх шатандаа байна.	
2.2	Тусгай зөвшөөрлийн болон цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр цахим мэдээллийн системийг хөгжүүлэх.							
2.2.1	Тусгай зөвшөөрлийн www.igov.mn цахим мэдээллийн системээс www.license.mn системрүү шилжүүлэх, тусгай зөвшөөрлийг цахимаар олгох үйл ажиллагааг хөгжүүлэх.	Улсын төсөв	Системийн ашиглалт хөгжүүлэлт /хувь/	50.0	0	100	Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 79 дугаар тогтоолын дагуу www.igov.mn цахим системийг Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд шилжүүлж, уг системийг бүрэн шинэчлэх ажил хийгдэж байна. Тус ажлын хүрээнд манай хэлтсээс цацрагийн үүсгүүрийн тусгай зөвшөөрлийг олгох үйл ажиллагааг Цөмийн энергийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн, www.license.mn цахим системд нэвтрүүлэхээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.	100%
2.3	ЦӨМИЙН МАТЕРИАЛ, ЦАЦРАГИЙН ҮҮСГҮҮРИЙН УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ							
2.3.1	Цацрагийн үүсгүүрийн ашиглалтын бүртгэл, жилийн	Улсын төсөв	Хянасан тайлан	70.0	0	85.0	Тайлант хугацаанд нийт 35 аж ахуйн нэгж байгууллагын цацрагийн	100%

	эцсийн тооллогын дүн, дотоод хяналтын тайланг хянах		/Хувь/				аюулгүй ажиллагааны дотоод тайланг хүлээн авсан.	
3.	ЗОРИЛТ 3. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
3.1	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.							
3.1.1	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх.	Улсын төсөв	Биелэлт гаргасан эсэх: 1-тийм 0-үгүй	0	1	1	- Газар, хэлтсийн болон төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг хуулийн хугацаанд гаргаж нэгжийн даргаар баталгаажуулж ажиллав. - Хяналт үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан Салбарын хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх хяналт шалгалтын удирдамжуудыг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 11/307 дугаартай албан бичгээр хүргүүлэв. - Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих цахим систем /igov.mn/ -ийн ашиглалтын өнөөгийн байдлын тухай мэдээллийг гаргаж 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлэв.	100%
3.1.2.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан	Улсын төсөв	Хууль тогтоомжийг биелүүлж ажилласан эсэх:	0	1	1	1. Тайлант хугацаанд хэлтсийн хэмжээнд нийт 1193 албан бичиг хүлээж авснаас хариугүй 472, хариутай 650 албан бичгийг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, 71	100%

	өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх		1-тийм 0-үгүй				албан бичиг судлагдаж байгаа, 4 албан бичиг хугацаа хожимдож шилжиж ирсэн шалтгаанаар хугацаа хэтэрч шийдвэрлэгдсэн байна. Хариутай албан бичгийн шийдвэрлэлт 97%-тай байна. 2. Төрийн захиргааны удирдлагын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн “Аж үйлдвэр, эрдэс баялгийн зохион байгуулалтын нэгжүүд 2024 оны шийдвэрлэгдсэн баримтаа архивд шилжүүлэх хуваарь”-ийн дагуу 2024 онд хянаж баталгаажуулсан шав тэмдгийн тайлангийн 12 боть бүхий 2453 хуудастай 76 тайлан, зөрчлийн гомдол мэдээллийн шийдвэрлэлтийн 23 зөрчлийн хэрэг бүртгэлийн 3 боть бүхий 527 хуудас хадгаламжийн нэгж, 2024 онд байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс ирсэн албан бичгийг стандартын шаардлагын дагуу архивын хадгаламжийн 5 нэгж нэгтгэн хадгаламжийн нэгж бүрдүүлж, архивд хүлээлгэн өгсөн. 3. Салбарын улсын байцаагчдын үнэмлэхийг “Өнгөт бийр” ХХК-д, тамга тэмдгийн “Шүрэн тамга” ХХК-д захиалж хийлгүүлэн, улсын байцаагчдад хүргүүлсэн.	
--	--	--	------------------	--	--	--	---	--

						4.Улсын байцаагчийн хяналт шалгалтын баримт бичгүүдээс хэвлэлтэд оруулаагүй байсан 3 төрлийн баримт бичгийг “АМЖА принтинг” ХХК хэвлүүлж, албан хэрэг хөтлөлтийн индекст оруулж батлуулав. 5. Салбарын хяналтын газрын 13 албан хаагчид 2024 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд бөглөж, хянуулж баталгаажуулсан. 6.Байгууллагын бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 13 албан хаагч хөрөнгө орлогын урьдчилсан мэдүүлгийг цахимаар бөглөж, хянаж баталгаажуулсан. 7.Төрийн албаны тусгай шалгалтад орж тэнцсэн Ц.Мөнхцэцэг, Т.Амарсайхан, Д.Пүрэвбат нар хөрөнгө орлогын урьдчилсан мэдүүлгийг цахимаар бөглөж, хянаж баталгаажуулсан.	
--	--	--	--	--	--	--	--

3.2.1	Ашигт малтмалын орд ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийн асуудал хэлэлцэх салбар зөвлөлийн хуралдаанд оролцох.	Улсын төсөв	Хуралдаанд оролцсон эсэх: 1-тийм 0-үгүй	0	1	1	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дэргэдэх Ашигт малтмалын орд ашиглах Техник, эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар зөвлөлийн хуралдаан тайлант хугацаанд 17 удаа хуралдаж 144 төслийг хэлэлцэж шийдвэрлэсэн. Өргөтгөсөн 4 удаагийн хурлаар 5 ТЭЗҮ-г хэлэлцэж шийдвэрлэсэн.	100%
